



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/44

Улаанбаатар хот

Хөрөнгө бүртгэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоол “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 3.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2018 оны А/67 дугаар захирамжийн дагуу нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдсэн “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хэрэглэгдэж буй програм хангамжуудыг холбох, нэгдсэн платформыг шинээр бий болгох, үе шаттай хөгжүүлэх” 479,000,000 /дөрвөн зуун далан есөн сая/ төгрөгийн үнэ бүхий системийг хавсралтын дагуу биет бус хөрөнгийн бүртгэлд бүртгэн авахыг нягтлан бодогч /Б.Бэхжаргал/-д зөвшөөрсүгэй.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны хэлтсийн дарга /И.Уранчимэг/-т үүрэг болгосугай.

Хавсралт 1. хуудастай.

ДАРГА



О.ЧИНЗОРИГ

1150500239



НМТГ-ын даргын 2018 оны 12 дугаар сарын
11 өдрийн АХД дугаар тушаалын хавсралт

БҮРТГЭХ БИЕТ БУС ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Гэрээний нэр: “Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хэрэглэгдэж буй програм хангамжуудыг холбох, нэгдсэн платформыг шинээр бий болгох, үе шаттай хөгжүүлэх”

Гэрээний дугаар: НМТГ-18/010

№	Гэрээт ажлын нэр	Нэр төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ /төгрөг/	Нийт дүн	НӨАТ /төгрөг/	Бүгд дүн /төгрөг/
1	“Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудад хэрэглэгдэж буй програм хангамжуудыг холбох, нэгдсэн платформыг шинээр бий болгох, үе шаттай хөгжүүлэх”	“UB ERP” дотоод удирдлагын систем	1 ш	435,454,545₮	435,454,545₮	43,545,455₮	479,000,000₮
НИЙТ					435,454,545₮	43,545,455₮	479,000,000₮